



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“ДУЛААНЫ ДӨРӨВДҮГЭЭР
ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
ДАРГА Ж.ОСГОНБААТАР ТАНАА

2015.04.13 № 12/14

Албан шаардлага өгөх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-ийг үндэслэн “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчилүүд илэрлээ. Үүнд:

- “ДЦС-4”ТӨХК-ийн 2014 оны нийт орлого, зардлын төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн шинжилгээгээр үндсэн үйл ажиллагаа болон үйл ажиллагааны бус зардал нь нийт дүнгээрээ 6,656.4 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Үүнд: Нийгмийн зардал-31% буюу 1,999.4 сая төгрөг, Үйл ажиллагааны бус бусад зардал-29% буюу 1,935.1 сая төгрөг, Цалингийн зардал-19% буюу 1,302.6 сая төгрөг байгаа нь нийт зардлын хэтрэлтийн 78.6 % буюу 5,237.1 сая төгрөгийг эзэлж байна. Тайлант хугацаанд түлш, түүхий эд материал, сэлбэг, албан томилолт, хангамжийн материал, хөдөлмөр хамгаалал, галын аюулаас хамгаалах болон урт хугацаат зээлийн хүүгийн зардлууд хэмнэгдсэн буюу тайлант хугацаанд нийт 4,513.6 сая төгрөгөөр зардлыг хэтрүүлсэн байна. Энэ нь төлөвлөгөөг зохиож, ТӨХ-оор батлуулахдаа бараа бүтээгдэхүүний үнэ тарифын өсөлт бууралт, зах зээл дээр өрсөлдөж буй ижил төрлийн үйлдвэрүүдийн нэгж бүтээгдэхүүнд ногдох зардлын харьцуулалт, хөдөлмөрийн бүтээмжийн хэлбэлзлийг тооцож шинжилгээ, судалгаа хийгээгүй, бодит байдлыг танилцуулан хангаж ажиллаагүйгээс дээрх зардлуудын хэтрэлт, хэмнэлтэд нөлөөлсөн байна. Мөн “Эрчим хүчний салбарын 2013-2014 оны хамтын хэлэлцээр, “ДЦС-4”-ийн захиргаа, ҮЭХ-ны хооронд байгуулсан хамтын гэрээ”-ний дагуу нэмэгдэл цалин урамшуулал, ажиллагсдын нийгмийн болон тэтгэвэр тусламж, орон сууцны хөнгөлөлт зэрэг зардлуудыг хэтрүүлэн олгож, ТӨХ-ны 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 555 дугаар тогтоолоор баталсан зорилтот түвшинг мөрдөн ажиллаагүй байна.
- Тус станцын Эрчим Зоогийн газар /ЭЗГ/, цайны өрөө /ЦӨ/, дэлгүүр гэсэн 3 нэгжийн хувьд 2014 онд 1,175.7 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүний худалдан авалт хийж, 1,589.4 сая төгрөгийн бараа материал, 1,378.2 сая төгрөгийн зардлыг үйл ажиллагаанд зарцуулж, нийт 2,967.6 сая төгрөгийн зардал гаргаж, 1,617.6 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласанаас 105.1 сая төгрөгийн бэлэн мөнгөний, 826.2 сая төгрөгийн зээлээр борлуулалт хийж, 657.5 сая төгрөгийн хөнгөлөлт эдлүүлж, 28.8 сая

төгрөгийн үнэ төлбөргүй үйлчилгээ /ҮАБЗардал/ үзүүлжээ. ДЦС-ын үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал /ҮНЗ/-ыг 2,036.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, алдагдалтай ажиллахад нөлөөлөх хүчин зүйл болсон учир Эрчим зоогийн газрын зохион байгуулалтын асуудлыг дахин авч үзэх буюу бүртгэл тооцоог сайжруулж үр ашигтай ажиллуулах арга хэмжээ авах шаардлагатай байна. /Хавсралт-1/

“Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ**:

Дээрх зөрчлүүдийг арилган, холбогдох арга хэмжээ авч, албан шаардлагын биелэлтийг 2015 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний Аудитын газарт албан ёсоор хариу ирүүлэхийг “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК-ийн захирал Ж.Осгонбаатар, Ерөнхий нягтлан бодогч Б.Цэндсүрэн нарт даалгав.

АХЛАХ АУДИТОР

Д.ГАНБИЛЭГ

